

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” УТҮГ 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/013/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Орхон аймаг 2026 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Мөнгө нөөц баялаг Аудит ХХК-ийн аудитор Б.Байгал Утас: 99359854 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.15 № 92
танай _____-ны № _____-Т

ОРХОН АЙМГИЙН "ХОТ
БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА
ЗАХИЛАГЧИЙН АЛБА" УТҮГ
ЗАХИРАЛ
Ц.НЭМЭХБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" УТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Орхон аймгийн "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" УТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Анхан шатны нотлох баримтгүй 2,711.1 мянган төгрөгийг компанийн дансанд шилжүүлж, шууд зардлаар тайлагнасан,
- Анхан шатны нотлох баримтгүй томилолтын зардал 6,773.0 мянган төгрөгийг ажилчдын дансанд шилжүүлсэн,
- Тайлант онд гэрээт төсөвчний ажлын хөлсийг олгохдоо гэрээнд заасан дүнгээс 1,530.0 мянган төгрөгөөр илүү тооцож, шилжүүлсэн,
- Анхан шатны нотлох баримтгүй "Алист костракшн" ХХК-ийн дансанд гэрээт ажлын хөлс гэсэн гүйлгээний утгатай 2,800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн,
- Тайлант онд аж ахуйн материал худалдан авахдаа 400.0 мянган төгрөгийг нийлүүлэгч компанийн дансанд илүү шилжүүлсэн,
- Компанийн 2025 оны шилдэг ажилтнуудын шагналд 5,000.0 мянган төгрөгийн төсөв баталж, зарцуулсан,
- Компанийн бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй урсгал засварын зардлаас 19,800.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Компанийн тухай хуулийн 84.4-д "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", 84.4.4-д "шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа тухай бүр мэдэгдэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой байгууллагаас авах 11,006.8 мянган төгрөгийн авлага үүсгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 3 дугаар сарын 24 өдрийн 02/21 дугаар тогтоолоор "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ-ыг Улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчилж, компанийн дүрэм, орон тоо цалин хөлсний нийтлэг жишгийг баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын дарга, нягтлан бодогч нар солигдож, байгууллагын үйл ажиллагаа явуулдаг оффис өөр байршилд нүүсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>505,335,842.20</u>	<u>15,928,847.77</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	493,841,567.77	412,690.52
31200	Банкиндах бэлэн мөнгө	493,841,567.77	412,690.52
31210	Төгрөг	493,841,567.77	412,690.52
31213	Арилжааны банк дах харилцах	493,841,567.77	412,690.52
33	АВЛАГА	908,348.43	11,811,407.25
33401	Бусад авлага		804,652.00
33402	Татвар, НДШ-ийн тайлан /ТӨҮГ/	908,348.43	11,006,755.25
35	БАРАА МАТЕРИАЛ	10,585,926.00	3,704,750.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	260,000.00
35400	Хангамжийн материал	10,585,926.00	1,665,400.00
35410	Бичиг хэргийн материал	0.00	1,779,350.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,247,261,245.56</u>	<u>2,706,709,473.89</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,247,261,245.56	2,706,709,473.89
39200	Үндсэн хөрөнгө	283,239,382.37	114,618,691.20
39201	Барилга, байгууламж орон сууц	17,231,943.77	8,615,971.89
39202	Хуримтлагдсан элэгдэл /Барилга, байгууламж орон сууц/	-6,206,897.16	-3,318,814.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,850,000.00	25,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл /Авто-тээврийн хэрэгсэл/	-29,574,500.00	-13,224,500.04
39205	Машин тоног төхөөрөмж	295,875,383.00	2,866,041.00
39206	Хуримтлагдсан элэгдэл /Машин тоног төхөөрөмж/	-142,053,746.60	-1,992,951.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,754,503.00	13,336,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл /Тавилга, аж ахуйн эд хогшил/	-36,637,303.64	-13,190,578.11
39209	Компьютер түүний дагалдах хэрэгсэл		209,497,216.36
39210	Хуримтлагдсан элэгдэл /Компьютер түүний дагалдах/		-112,970,493.70
39300	Биет бус хөрөнгө	2,964,021,863.19	2,592,090,782.69
39301	Программ хангамж	16,385,000.00	17,385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл /Программ хангамж/	-8,554,100.02	-3,506,166.71
39303	Бусад биет бус хөрөнгө	3,027,585,766.00	2,935,824,511.00
39304	Хуримтлагдсан элэгдэл /Бусад биет бус хөрөнгө/	-71,394,802.79	-357,612,561.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,752,597,087.76</u>	<u>2,722,638,321.66</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>92,577,337.34</u>	<u>12,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	92,577,337.34	12,000.00
41300	Өглөг	92,577,337.34	0.00
41360	Бусад өглөг	92,577,337.34	12,000.00
41363	Татварын өглаг /ТӨҮГ/	92,577,337.34	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,660,019,750.42</u>	<u>2,722,626,321.66</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,660,019,750.42	2,722,626,321.66
51101	Өмч /төрийн /ГГӨҮГ/	3,237,699,079.22	3,014,473,403.79
51200	Хуримтлагдсан үр дүн	421,365,208.43	-291,847,082.12
51210	Өмнөх үеийн үр дүн	341,995,079.43	141,346,051.51
51220	Тайлант үеийн үр дүн	79,370,129.00	-433,193,133.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	955,462.77	0.00
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>3,752,597,087.76</u>	<u>2,722,638,321.66</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,692,671,457.27	1,256,911,456.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,692,671,457.27	1,256,911,456.87
120	Нийтлэг татварын бус орлого	1,692,671,457.27	1,256,911,456.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогос санхүүжих	-	744,465,958.14
120010	Борлуулалтын орлого цэвэр дүн	1,692,671,457.27	512,445,498.73
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,607,815,757.27	1,690,104,590.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,607,815,757.27	1,690,104,590.50
2108	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,607,815,757.27	1,690,104,590.50
210810	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төблөр хураамж	-	488,359,633.67
210814	Борлуулалт маркетингийн зардал	1,607,815,757.27	1,004,445,318.59
210815	Санхүүгийн зардал	-	197,299,638.24
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	84,855,700.00	-433,193,133.63
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	84,855,700.00	(433,193,133.63)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.0	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,886,309,276.00	1,265,748,857.44
1.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,886,309,276.00	1,265,748,857.44
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,854,935,103.00	521,282,899.30
1.1.6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,374,173.00	744,465,958.14
1.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	1,562,507,828.96	1,725,087,734.69
1.2.1	Ажиллагчдад төлсөн	760,578,567.00	784,549,286.34
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	204,765,053.35	123,499,036.48
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	29,983,880.00	123,807,723.38
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	51,835,135.86	2,673,384.95
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	16,053,484.00	12,756,500.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	128,500,555.12	79,609,051.74
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,905,120.00	960,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	368,886,033.63	597,232,751.80
1.3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	323,801,447.04	(459,338,877.25)
2.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	93,346,260.00	34,090,000.00
2.2.1	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	93,346,260.00	34,090,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(93,346,260.00)	(34,090,000.00)
4.1	БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	230,455,187.04	(493,428,877.25)
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	263,405,380.73	493,841,567.77
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	493,841,567.77	412,690.52

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,703,870,424.22	955,462.77	-	1,704,825,886.99
2	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,237,699,079.22	955,462.77	355,997,876.47	3,594,652,418.46
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	49,370,139.00	49,370,139.00
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(204,854,533.66)	(204,854,533.66)
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
8	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	3,237,699,079.22	955,462.77	200,513,481.81	3,439,168,023.80
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(59,167,430.30)	(59,167,430.30)
10	Залруулсан үлдэгдэл	(223,225,675.44)	-	141,346,051.51	(81,879,623.93)
11	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(433,193,133.63)	(433,193,133.63)
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
13	Өмчид гарсан өөрчлөлт	(223,225,675.44)	-	-	(223,225,675.44)
14	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
15	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
16	2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	3,014,473,403.79	-	(291,847,082.12)	2,722,626,321.66

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Мерийн дугаар	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувиар
1	Борлуулалтын орлого	1,852,084,300.00	512,445,498.73	1,339,638,801.27	28%
2	Бусад орлого	50,000,000.00	744,465,958.14	(694,465,958.14)	1489%
3	Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн	1,902,084,300.00	1,256,911,456.87	645,172,843.13	66%
4	Үндсэн цалин	956,810,180.00	784,549,286.34	172,260,893.66	82%
5	АО-ын НДШ төлөлт	119,601,270.00	103,316,548.23	16,284,721.77	86%
6	Тэтгэмж урамшуулал	94,929,000.00	-	94,929,000.00	0%
7	Ахмадын сан	3,000,000.00	-	3,000,000.00	0%
8	Томилолтын зардал	28,000,000.00	11,917,361.73	16,082,638.27	43%
9	Сургалтын зардал	21,180,000.00	5,635,000.00	15,545,000.00	27%
10	Мэдээлэл холбооны зардал	8,724,500.00	13,236,125.38	(4,511,625.38)	152%
11	Даатгалын зардал, АТБӨЯХАТ	1,693,500.00	2,275,000.00	(581,500.00)	134%
12	Бичиг хэрэгийн зардал	17,100,000.00	7,287,181.81	9,812,818.19	43%
	Банкны үйлчилгээний зардал	-	80,600.00	(80,600.00)	-100%
13	Засвар үйлчилгээ багаж хэрэгслийн зардал	20,500,000.00	3,323,507.74	17,176,492.26	16%
14	Барилга ашиглалт /ус, дулаан, цахилгаан/	14,492,400.00	3,527,614.63	10,964,785.37	24%
15	Компьютер принтерийн сэлбэг хэрэгсэл үйлчилгээний зардал	13,579,700.00	16,362,500.00	(2,782,800.00)	120%
16	ХАБЭА-н зардал	42,109,600.00	7,119,427.27	34,990,172.73	17%
17	Түрээсийн зардал	47,904,800.00		47,904,800.00	0%
18	Шатахууны зардал	24,032,800.00	11,596,818.19	12,435,981.81	48%
19	Маркетингийн зардал	41,100,000.00	9,635,000.00	31,465,000.00	23%
20	Гадна байгууллагатай хамтарсан арга хэмжээний зардал	116,350,000.00	107,878,636.09	8,471,363.91	93%
21	Шинээр ү/х худалдан авсан зардал	17,950,000.00	33,067,272.73	(15,117,272.73)	184%
22	Авто сэлбэг хэрэгсэл засвар үйлчилгээ	10,300,000.00	9,108,500.00	1,191,500.00	88%
23	Бусад мөнгөн зардал /дотоод ү/а-ны зардал/	53,605,000.00	2,744,565.59	50,860,434.41	5%
24	Элэгдлийн зардал	46,500,000.00	360,144,006.54	(313,644,006.54)	775%
25	НӨАТ-н татвар	175,000,000.00	-	175,000,000.00	0%
26	Бусад санхүүгийн зардал	-	197,299,638.24	(197,299,638.24)	-100%
27	Зардлаын дүн	1,874,462,750.00	1,690,104,590.50	381,657,797.74	90%
28	Ашиг+, Алдагдал-	59,522,400.00	(433,193,133.63)	492,715,533.63	-728%
29	Татвар	5,952,240.00	-	5,952,240.00	0%
30	Татварын дараах ашиг алдагдал	53,570,160.00	(433,193,133.63)	486,763,293.63	-809%
31	Ажилчдын тоо	28.00	22.00	6.00	79%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 361.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 280.0 сая төгрөгийн алдааг залруулж, 81.1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл үндсэн хөрөнгийн элэгдэл илүү бодогдсон 220.9 сая төгрөг, өмнөх оны аудитлагдсан эргэлтийн бус хөрөнгийн алдааны дүн 59.2 сая төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулгаар залруулж өмнөх үеийн үр дүн данс руу бичилт хийж залруулсан.

Аудитаар нийт 81.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 14.2 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 24.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 42.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Анхан шатны нотлох баримтгүй 2,711.1 мянган төгрөгийг компанийн дансанд шилжүүлж, шууд зардлаар тайлагнасан, томилолтын зардал нэрээр 6,773.0 төгрөгийг ажилчдын дансанд шилжүүлсэн, гэрээт төсөвчний ажлын хөлсийг олгохдоо гэрээнд заасан дүнгээс 1,530.0 мянган төгрөгөөр илүү тооцож, шилжүүлсэн, анхан шатны нотлох баримтгүй "Алист кострактшн" ХХК-ийн дансанд гэрээт ажлын хөлс гэсэн гүйлгээний утгатай 2,800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, аж ахуйн материал худалдан авахдаа 400.0 мянган төгрөгийг нийлүүлэгч компанийн дансанд илүү шилжүүлсэн зөрчлүүдэд 5 төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Анхан шатны баримт бүрэн бүрдүүлээгүй 5.0 сая төгрөг, урсгал засварын зардлаар хөрөнгө бэлтгэсэн 19.8 сая төгрөгийн зөрчлүүдэд 2 албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөлсөөр ажиллах гэрээгээр гүйцэтгэсэн 22.3 сая төгрөгийн ажлын баримт болох зураг болон төсөв хийсэн баримтуудыг цахимаар хүлээн авсан байна. Уг хяналтын төсвүүд, ажлын зургуудын бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтын талаар тодорхой дүрэм, журам байхгүй байна.

Энэ нь Хууль зүй дотоод хэргийн Сайдын 2025 оны оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/100 дугаар тушаалын 8.5-д "Байгууллага нь баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажилтантай нууц хадгалалтын гэрээ байгуулна. Ажилтан нь баримттай болгоомжтой харьцаж, гэмтээхгүй, мэдээлэл тээгчийн чанарыг муутгахгүй, баримтын гадаад, дотоод онцлог шинж болон мэдээллийн үнэн, бодит байдлыг алдагдуулахгүй, өөрчлөхгүй байх үүрэг хүлээнэ", 8.1-д "Байгууллагын удирдлага цахим тогтолцоо нэвтрүүлж, кибер халдлагаас сэргийлэх, мэдээлэл, сүлжээ, серверийн болон техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах арга хэмжээг тогтмол авч, хяналт тавьж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллана.", 9.1-д "Архивын баримтын бүрэн бүтэн байдал, хадгалалт, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор тоо бүртгэл хөтөлнө. Тоо бүртгэл нь архивын баримтын хэлбэр, бүрэлдэхүүн, тоо хэмжээ, өөрчлөлт хөдөлгөөнийг тогтоосон нэгж хэмжигдэхүүнээр тэмдэглэх үйл ажиллагаа юм." гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Зураг төсөв, хяналтын төсвүүдийг цахимаар хүлээн авах, хадгалах журмыг боловсруулж, мөрдөж ажиллах

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 19.8 сая төгрөгөөр тавилга эд хогшлын шууд худалдан авалтыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5.5-д "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна." Сангийн сайдын 2023 оны баталсан ТБӨНӨХБАҮХА ажиллагааг төлөвлөх тайлагнах журмын 3.9-д "Шууд худалдан авалт хийсэн захиалагч тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулсан байна." гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шууд худалдан авалт хийсэн хийсэн тохиолдолд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, гэрээний үнийн дүнг цахим системд оруулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Тайлант онд аж ахуйн материал худалдан авахдаа 400.0 мянган төгрөгийг нийлүүлэгч компанийн дансанд илүү шилжүүлсэн байна.	1	400.0	1	400.0								
Компанийн 2025 оны шилдэг ажилтнуудын шагналд 5,000.0 мянган төгрөгийн төсөв баталж, зарцуулсан байна.	1	5,000.0			1	5,000.0						
Компанийн бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй урсгал засварын зардлаас 19,800.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.	1	19,800.0			1	19,800.0						
Хөлсөөр ажиллах гэрээгээр гүйцэтгэсэн 22,280.0 мянган төгрөгийн ажлын баримт болох зураг болон төсөв хийсэн баримтуудыг цахимаар хүлээн авсан байна. Уг хяналтын төсвүүд, ажлын зургуудын бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтын талаар тодорхой журам дүрэм байхгүй байна.	1	22,280.0					1	22,280.0				
Дүн	8	61,294.1	5	14,214.1	2	24,800.0	1	22,280.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд 19,800.0 төгрөгөөр тавилга эд хогшил шууд худалдан авалтыг шилэн дансанд мэдээлээгүй байна.	1	19,800.0					1	19,800.0
Дүн	1	19,800.0					1	19,800.0